

## Байгалийн хуулийн онол дахь хүний эрх ба ёс суртахууны үнэт зүйлийн философийн үндэс

Д.Оюунгэрэл, доктор (PhD), дэд профессор  
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Г.Эрдэнэбаяр, доктор (PhD), дэд профессор  
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

**Хураангуй:** Байгалийн хуулийн онол нь ёс зүйн нэгэн бие даасан онол юм. Энэ онол ёсоор хүн төрөлхтөнд байгалиас заяасан, ижил тэгш эдлэх ёстой, өөрчлөгдөшгүй эрх байдаг. Хүний эрхийн тухай ойлголт нь хүн төрөлхтний философи, улс төр, хууль эрх зүйн чухал асуудлын нэг байсаар ирсэн бөгөөд зөвхөн нэг улс орны хууль тогтоомжийн хүрээний биш, бүх нийтэд хамаатай үнэт зүйл юм. Энэ үзэл санааг байгалийн хууль буюу хүн төрөлхтөнд төрөлхөөс заяагдсан, салиггүй эрхийн тухай тайлбарладаг үзэл баримтлалаас урган гарсан хэмээн үзэх нь бий. Байгалийн хуулийн онол нь тухайн улсын эрх зүйн тогтолцооноос үл хамааран хүн төрөлхтөнд нийтлэг үйлчлэх обьектив зарчим байдаг гэсэн агуулгыг илэрхийлдэг.

**Түлхүүр үг:** Байгалийн хууль, хүний эрх, эрх чөлөө, ёс суртахуун, түгээмэл зарчим

**Байгалийн хуулийн онолын түүхэн эхлэл** Байгалийн хуулийн онол нь хүн төрөлхтний сэтгэлгээний түүхэнд эрх, эрх чөлөө, ёс суртахууны суурь ойлголтыг тайлбарлах ёс зүй - философийн нэгэн чухал үзэл баримтлал болон төлөвшжээ. Энэ онолын санаа Аристотель, стоикууд болон Цицерон нараас эхлэлтэй (Barbara MacKinnon, 2018) гэдэг бөгөөд Фома Аквина, Жон Локк, Томас Жефферсон зэрэг сэтгэгч өөрсдийн байр сууринаас агуулгыг баяжуулан тайлбарласан байна. Тэдний дэвшүүлсэн санаа нь ёс зүй, шашин, хүний эрхийн тухай хэлэлцүүлгийн чухал үндэслэл болсоор иржээ.

Эртний Грекийн философич Аристотель хүнийг нийгмийн амьтан хэмээн үзэж, түүний сайн сайхан амьдралд чиглэсэн байгалийн хууль оршдог гэж тайлбарласан нь дундад зууны философич Фома Аквинад (1224–1274) хүчтэй нөлөөлсөн. Аристотелийн үзлээр “хүн бол нийгмийн, оюун ухаант амьтан, тиймээс бидний зорилго бол зөв, ухаалаг амьдарч сайн сайхныг бүтээх явдал” (Даш-Ёндон, 2011) гэжээ. Цицерон ч үүнтэй адил “Ямар ч хаан, ямар ч хууль тогтоогчоос давж гарч чадахгүй, цаг хугацаа, орон зайнаас үл хамаарах мөнхийн хууль байдаг, тэр нь байгалиас заяасан хууль” (Cicero, 2020) гэж үзсэн байдаг. Энэ санааг Аквина цааш хөгжүүлж “Сайныг хийж, мууг цээрлэх нь хүн бүрийн байгалийн хууль мөн” (M.Кауе, 2008) гэж тодорхойлсон. Бусад бүх зарчим гагцхүү үүнээс урган гарна.

Фома Аквина байгалийн хуулийг шашны утгаар өргөжүүлэн, хүний оюун ухаанаар таньж болох ёс суртахууны хууль хэмээн тайлбарласан. Байгалийн хуулийн онол (ёс суртахууны онол) нь бодит амьдралын янз бүрийн нөхцөлд юу хийвэл зөв болохыг бидэнд хэлж туслах болно.

Фома Аквина хуулийн дөрвөн төрлийг (M.Кауе, 2008) авч үзжээ. Үүнд:

- 1) Мөнхийн хууль: Бүтээгч Эзэний орчлон ертөнцийг захирах түгээмэл, дээд хууль.
- 2) Тэнгэрлэг хууль (Библийн хууль): Бурхан тэнгэр хүнийг өөртэйгөө хамт байж, мөнхийн аз жаргалд хүргэх тухай санааг илэрхийлнэ.
- 3) Байгалийн хууль (ёс суртахууны хууль): Мөнхийн хуулийн нэг хэсэг бөгөөд оюун ухааны тусламжтай хүний сонголтод нөлөөлж байдаг.

- 4) Хүний хууль (иргэний хууль): Байгалийн хуулийг нийгмийн нөхцөл байдалд тохируулан хэрэглэхийн тулд хүний зохиосон хууль тус тус болно.

Байгалийн хууль нь мөнхийн хуулийн нэг хэсэг бөгөөд хүний эрх, шударга ёсны эх үндэс болдог хэмээн тайлбарласан. “Харин хүний хууль нь байгалийн хуулийг тодорхой, нарийвчилсан байдлаар хэрэгжүүлдэг” (M.Кауе, 2008) гэж тэр үзсэн.

Аквины тайлбарласнаар хүний төрөлхийн чиг хандлага бол өөрийгөө, гэр бүлээ, нийгмээ хамгаалахад оршино. Энэ нь бусдыг хорлохгүй, өөрийгөө болон бусдыг эрх чөлөөтэй, оюун ухаантай оршихуй гэж үзэх байдлаар илрэх бөгөөд байгалийн хуульд нийцнэ. “Ёс суртахууны сайн үйлийг тодорхойлох гол зүйл бол итгэл, найдвар, энэрэл, хянамгай байдал, биеэ барих чадвар, тэсвэр тэвчээр, шударга ёс” (Flannery, 2003) хэмээн үзсэн байдаг. Тиймээс боловсрол эзэмших, үнэнийг мэдэх, чөлөөт сонголт хийх боломж зэрэг нь сайн үйлд тооцогдож, харин хүчээр тулгах, хүний сонголтыг хязгаарлах нь муу үйл болно. Дээрх муу үйлийн шалтгаанаас шунахай зан, доог тохуу хийх, хов жив, гүтгэлэг, үл тоомсорлол, хардах, дайсагнал, харгислал зэрэг үр дагавар гарч болохыг тэрээр тайлбарлажээ.

Байгалийн хуулийн онол бол Фома Аквины ёс зүй, улс төрийн сэтгэлгээний нэгэн хэсэг бөгөөд түүний философид чухал үүрэг гүйцэтгэдэг. Байгалийн хуулийн онолыг бие даан хөгжихэд гол нөлөө үзүүлсэн тэрээр шашны агуулгатайгаар тайлбарлаж байснаараа бусад төлөөлөгчөөс ялгардаг. Хүний оюун ухаанд хүртээмжтэй ертөнцийн үндсэн хэсэг болох байгалийн хууль нь хүний хөгжил, сайн сайхан амьдралд саад учруулах үйлийг хийхгүй байх ёс суртахууны зорилгыг агуулна.

Ийнхүү “байгалийн хууль нь хүн төрөлхтөнд бурхан тэнгэрээс заяасан үндсэн шинж чанартай тул мөн чанараараа эрх чөлөө, аз жаргалыг эрэлхийлдэг” (M.Кауе, 2008) ажээ. Аквины боловсруулсан байгалийн хуулийн онол нь “оюун ухаан ба итгэл бишрэлийн цогцыг илэрхийлдэг тул хүний төрөлхийн нэр төр, үнэ цэнийн талаарх итгэл үнэмшилд суурилсан улс төрийн шийдвэр гаргах тогтолцоог бүрдүүлдэг” [Finnis, 2011] хэмээн түүний онолыг дэмжигчид үзжээ. Тухайлбал, Австралийн философич Жон Финнис<sup>1</sup> байгалийн хуулийн онолыг хүний эрхийн талаас үнэлж бичсэн бүтээлдээ “хүнийэрхийг хамгаалах нь нийтийн сайн сайхны үндсэн бүрэлдэхүүн хэсэг болохыг Фома Аквина харуулсан” (Finnis, 2011) хэмээн дүгнэсэн байна.

Аквиний үзэж байгаагаар байгалийн хууль нь бүх хүнд хамаарах ёс суртахууны жишиг бөгөөд энэ нь хүний зохиосон хууль, дүрэм журмын үндэс суурь болдог. Хүний зохиосон хууль нь байгалийн хуультай нийцэж байх ёстой бөгөөд зөвхөн энэ тохиолдолд шударга бөгөөд хүчин төгөлдөр гэж тооцогдоно. Харин байгалийн хуультай зөрчилдөж буй хууль бол хүчин төгөлдөр бус юм. Иймээс байгалийн хууль нь нийгэмд үйлчилж буй эрх зүй, ёс суртахууны үнэт зүйлийг тодорхойлох үндсэн суурь болж өгдөг. Фома Аквины үзлээр энэ ертөнц мөн чанараараа сайн бөгөөд үүний шалтгаан нь бурхан тэнгэр бүх сайны дээд нь юм. Түүний эл санааг ядуурлыг бууруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч тэтгэх, зохистой хөдөлмөр эрхлэх, аюулгүй тайван амьдрах гэх мэт нийгмийн шударга ёсыг хөгжүүлэх үзэл санааны нэгэн чухал үндэслэл болгон цаашид тайлбарлах болсон байна.

“Бүх хүнд юу зөв, юу буруу болохыг мэдрэх төрөлхийн мэдрэмж байдаг бөгөөд энэ нь байгалийн хуулинд тулгуурладаг” (Barbara MacKinnon, 2018) гэж тэрээр үзсэн.

---

<sup>1</sup> Эрх зүйн философ, метафизик, танин мэдэхүйн онол, ёс суртахууны философиор мэргэшсэн. Тэрээр Аристотель, Фома Аквина нарын философийн тайлбараар алдартай.

Байгалийн хууль нь нэгэнт Бурхан тэнгэртэй холбогдох тул ёс суртахуунтай шийдвэр гаргах, улс төрийн засаглалын тогтолцоог бүрдүүлэхэд чухал оролцоотой гэж үздэг. Хүний зохиосон хуулиуд нь байгалийн хуулинд суурилсан байх ёстой бөгөөд тэдгээр нь нийтлэг сайн сайхныг дэмжих, хүний төрөлхийн сайн сайхныг хамгаалах зорилготой ажээ. Байгалийн хууль нь ийнхүү хүн бүрт хамаатай түгээмэл, өөрчлөгдөшгүй шинж чанартай хэмээн онцолж байсан нь хүний эрхийн тухай үзэл санааг тайлбарлах нэг үндэслэл болж өгчээ.

**Байгалийн хууль ба орчин үе** Шинэ үеэс эхлэн байгалийн хуулийн онолыг шашны агуулгаас салгаж тайлбарлах болсон. Нидерландын хуульч Хюго Гроциус (1583–1645) байгалийн хуулийг олон улсын эрх зүйн үндэс болгох тайлбарыг өгч байжээ. Тэрээр “Байгалийн хуулийн эх нь хүний мөн чанар байна. Иргэний хууль нь харилцан гэрээнээс урган гардаг. Тиймээс байгалийн хууль бол иргэний хуулийн эх үндэс мөн” (Barbara MacKinnon, 2018) гэжээ. Хэрэв бүх хүнд жам ёсны эрх бий гэж үзвэл дайн байлдааны үед ч тэдгээрийг хамгаалах ёстойг тэрээр энэ санаагаараа дамжуулан тайлбарласан нь олны анхаарлыг татсан байна. Түүнчлэн байгалийн хуулийн онолыг хүний мөн чанарт үндэслэн тайлбарлахдаа зөвхөн эерэг шинжийг чухалчилдгийг Т.Хоббс эсэргүүцсэн. Түүний үзлээр хүнийг уг чанартаа муу, шуналтай гэж үзээд, хүчтэй төр, ухаалаг дүрэм байхгүй бол амьдрал хэрцгий, богинохон болохыг бичсэн байдаг.

Байгалийн хуулийн онолыг хүний эрхийн зарчимд тулгуурлан тайлбарласан өөр нэг хүн бол Томас Жефферсон юм. Тэрээр 1776 онд Тусгаар тогтнолын тунхаг бичигт “Бүх хүн адил тэгш бүтээгдсэн бөгөөд бүтээгч нь тэдэнд салшгүй эрхүүдийг олгосон, үүнд амьд явах, эрх чөлөөтэй байх, аз жаргалыг эрэлхийлэх зэрэг багтана. Бид эдгээр үнэнийг өөрөө илэрхий гэж үздэг” (Jefferson, 1776) гэж бичсэн нь байгалийн хуулийн онолын илэрхийлэл хэмээн үздэг байна. Түүний энэ санааг Ж.Локкийн үзлийн шууд нөлөөлөл гэж хэлж болно. Английн философич Ж.Локкийн “Бүх хүн төрөлхөөсөө тэгш эрхтэй бөгөөд адилхан чадвар, чадамжтай төрдөг” (Locke, 2003) гэдгийг Томас Жефферсон “Бүх хүн тэгш эрхтэй төрдөг” хэмээн онцолсон. Энэ нь хүн хаана төрснөөс үл хамааран нийтлэг эрх эдлэх ёстойг баталгаажуулсан. Ж.Локкийн үзсэнээр хүн төрөлхтөн төрөлхөөсөө жам ёсны эрхтэй төрдөг учир бүгдтэй адил тэгш харилцах ёстой. Амьд явах эрх, эрх чөлөөтэй байх, өмч эзэмших зэрэг нь төрөөс өгдөг бус, төрөлхийн буюу хүн болж төрснийх нь хувьд заавал эдлэх ёстой эрх билээ. “Хүн анхнаасаа ямар нэгэн дарангуйлал, эрх мэдлийн хуваарьгүй, эрх чөлөөтэй төрдөг, хүн бүрийн үнэ цэн, чадвар, боломж ижил, хэн ч анхнаасаа бусдаас илүү эрхтэй төрөөгүй” (Locke, 2003) болохыг тунхаглаж өгснөөрөө энэхүү үзэл хүн төрөлхтний түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Энэ нь Кантын боловсруулсан деонтологи онол ёсоор “Хүн төрөлхтөнд, чиний бие ч бай, өөр хэн нэгэн ч бай хэрэгсэлд огт бус, харин зорилгод холбогдож байхаар үйлд” (Ричард Поупкин, 1998) гэж үзэх үзэлтэй дүйж байгаа юм. Ж.Локк ба Т.Жефферсон нарын хувьд энэ санааг амьд явах, эрх чөлөөтэй байх зэрэг байгалиас заяасан жам ёсны эрхээр тайлбарлаж тодорхойлсон. Тэр дундаа Ж.Локк өмчтэй байх эрхийг байгалийн буюу жам ёсны хэмээн үзсэн бол Т.Жефферсон хүний аз жаргалыг эрэлхийлэх эрхийг чухалчилсан.

Энэ онолын төлөөлөгчдийн үзлээр, байгалийн хууль бол бусад бүх дүрэм зарчмын суурь байдаг. Үндсэн зарчим нь “сайныг хийж, түүнд тэмүүлж, муугаас зайлсхийх явдал” юм. Хүн төрөлхтний хийх ёстой зүйл бол байгалиас заяасан сайн сайхны төлөө байж, харин муу зүйлийг яагаад муу гэдгийг ойлгож, улмаар зайлсхийх ёстой. XX зууны түүхэнд хүний эрхийн олон ноцтой зөрчлүүд бий болсон бөгөөд

тухайлбал, дэлхийн II дайны үед боолын хөдөлмөр эрхлүүлэх, шалтгаангүйгээр амь насыг хохироох, шинжлэх ухааны туршилтад зүй бусаар оруулах гэх мэт харгис түрэмгийлэл, хүчирхийлэл үйлдэгдсэн. Нацистуудын удирдагчид олон улсын хууль, дүрмийг зөрчсөн хэргээр ял авч, зарим нь цаазлуулсан. Эмч нар хорих лагерьт хүн дээр туршилт хийсэн хэргээр яллагдсан. Тэд дээд удирдлагынхаа тушаалыг биелүүлсэн гэж өөрсдийгөө хамгаалсан ч прокурорууд “Хүмүүнлэг энэрэнгүйн эсрэг гэмт хэрэг бол иргэний хуулиас давсан, байгалийн хуульд харшилсан үйлдэл” (Barbara MacKinnon, 2018) гэж үзсэн. Зүй нь Аквины боловсруулсан онол ёсоор “Хүн бол бурхан тэнгэрийн бүтээл төдийгүй нийгмийн амьтан тул бусдын сайн сайхны төлөө ажиллах, шударга ёсыг эрхэмлэх” (Skorupski, 2010) ёстой тул хүнийг харгис туршилтад оруулах бус, хүндлэл халамжаар хамгаалах нь байгалийн хуулийн хүрээнд хамаарна.

Жам ёсны эрхийг зөрчсөн харгис хэрцгий үйлдэл олноор гарсан явдал нь иргэний буюу хүний зохиосон хуулиуд байгалийн хуульд нийцэж чадаагүйн илрэл хэмээн үзэж, тухайн улсын хуульд өөрчлөлт оруулах эсхүл эсэргүүцэх үндэслэл мөн болохыг илэрхийлж байжээ. Тухайлбал, ялгаварлан гадуурхалыг “иргэний дуулгаваргүй байдал”-р Хенри Дэвид Торо, хүчирхийллийг Махатма Ганди, Мартин Лютер Кинг нар хүчирхийллийн бус онолоороо тус тус эсэргүүцэж буйгаа илэрхийлсэн. Хенри Дэвид Торо шударга бус дайнд татвар төлөхөөс татгалзсаны улмаас хоригдож байжээ. Тэрээр “Хүн хууль тогтоогчийн өмнө биш, өөрийн ухамсрын өмнө хариуцлага хүлээх ёстой. Буруу хуульд биш, зөвд хүндэтгэл үзүүлэх нь илүү чухал” (Barbara MacKinnon, 2018) гэж хэмээн илэрхийлж байжээ. Нэгэнт байгалийн хуульд нийцүүлж сайн хууль зохиож чадаагүй үед хүмүүсийн хандах, чиг баримжаагаа болгох хууль бол байгалийн хууль мөн гэсэн итгэл үнэмшил байжээ.

Байгалийн хуулийн онол нь ёс суртахууны үнэт зүйлсийг объектив гэж үзэж, хүний сайн сайхан, хөгжлийг зорилго болгож хүний эрх, үнэт зүйл, ёс суртахууны төлөвшилд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн ч энэ онол нь нийгмийн хандлагын зөрчилдөөнүүдийг бүрэн шийдвэрлэх боломжгүй гэдгийг түүнийг шүүмжлэгчид илэрхийлдэг. Түүхэнд боолчлол, хүйсийн ялгаварлал, нийгмийн тэгш бус байдлыг “байгалийн хууль” нэрийн дор зөвтгөсөн тохиолдол бий.

Сайн үйлийг байгалийн хуулийн онолд бурхан тэнгэрээс өгөгдсөн төрөлхийн шинжтэй хэмээн үздэг. Тухайлбал, Жефферсон “Тусгаар тогтнолын тунхаглал”-д сайн үйлийг “өөрөө илэрхий” (Jefferson, 1776) гэж бичсэн. Гэвч бодит байдал дээр олон зуун жилийн турш боолчлол, эмэгтэйчүүдийн эрх тэгш бус байдал байсаар байгаа нь өөрөө илэрхий биш гэдгийг харуулж байна хэмээн шүүмжлэх нь бий.

### Дүгнэлт

Ёс зүй дэх байгалийн хуулийн онол нь хүн төрөлхтний түүхэнд хүний эрх, ёс суртахууны харилцан хамаарлыг тайлбарласан чухал онолын нэг болон төлөвшжээ. Өөрөөр хэлбэл, нийгмийн шударга ёсны төлөө тэмцэл, хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээрийн суурь нь болж өгсөн нь үүний илрэл юм. Фома Аквина ёс суртахууны ухамсар, ёс суртахуунлаг сайн үйлийг байгалийн хуультай холбон тайлбарлаж, хүнийг “ёс зүйн хариуцлагатай оршихуй” хэмээн үнэлсэн байдаг. Хүн ёс зүйн хариуцлагатай оршихуйн хувьд өөрийн болон бусдын эрх чөлөөг хүндэтгэж, сайн үйлийг хийдэг хэмээн үзсэн нь хүний эрх, эрхийн ёс зүйн үндэс болж өгчээ. Байгалийн хуулийн онолыг хөгжүүлэгчид Ж.Локкийн боловсруулсан хүний эрх, эрх чөлөөний үнэ цэнийг дээдэлсэн санааг байгалийн хуулийн онолд тулгуурлан тайлбарлах болсон нь өнөөгийн хүний эрхийн боловсрол, эрх зүйт төр, ардчиллын боловсролын философийн суурь болж өгсөн байна. Эцэст нь, хэдийгээр энэ онолыг

шүүмжилсэн, эргэлзсэн байр суурь олон байсан ч нийгмийн шударга ёс, хүний эрх, тэгш байдал, ёс суртахууны үнэт зүйлсийг тайлбарлахад өргөн хэрэглэдэг онолын нэг болжээ.

### Ном зүй

Barbara MacKinnon, A. F. (2018). *Ethics: Theory and Contemporary Issues*. USA: CLDPC.

Cicero, M. T. (2020 December 19). *Cicero's Tusculan Disputations*. Project Gutenberg: <https://www.gutenberg.org/ebooks/14988>

Finnis, J. (2011). *Natural Law and Natural Rights*. London: Oxford University Press.

Finnis, J. (2011). *Natural Law and Natural Rights*. London: Oxford University Press.

Flannery, K. (2003). The Multifarious Moral Object of Thomas Aquinas. *The Thomist: A Speculative Quarterly Review, Volume 67*, 95-118.

Jefferson, T. (1776, July 4). *America's Founding Documents*. Retrieved from National Archives: <https://www.archives.gov/>

Locke, J. (2003, April 22). *Second Treatise of Government*. Retrieved from The Project Gutenberg eBook : <https://www.gutenberg.org>

M.Kaye, S. (2008). *Medieval philosophy*. Oxford : Oneworld Publications .

Skorupski, J. (2010). *The Routledge Companion to Ethics*. London and New York: Routledge. Taylor Francis Group.

Даш-Ёндон. (2011). *Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж*. Улаанбаатар: Интерпресс.

Сартр, Ж.-П. (2007). *Экзистенциализм бол хүмүүнлэг үзэл мөн*. Улаанбаатар

Ричард Поупкин, А. С. (1998). *Гүн ухаан*. Улаанбаатар: ШУА, ФСЭХ.

## **The philosophical foundation of Human Rights and Moral Values in the Natural Law Theory**

*This paper discusses the theme of natural law theory in ethics. Natural law consists of certain first principles of morality which are broadly shared, and which provide a basis for the historical development of human laws. Natural law theory argues that we ought to find ways to live well together. We are social creatures by nature. Thus, the essence of natural law theory is that we ought to further the inherent ends of human nature and not do what frustrates human fulfillment of flourishing, deprive human rights.*